



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 4251

Улаанбаатар хот

Журам, зөвлөлийн бүрэлдэхүүн
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.16, 30.1.19 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшиг судлал, инновац" онол, аргазүйн мэргэжлийн сэтгүүлийг эрхлэн гаргах журмыг нэгдүгээр, "Гамшиг судлал, инновац" сэтгүүлд хэвлүүлэхээр ирүүлсэн өгүүлэлд хянан магадалгаа хийж үнэлгээ өгөх хуудсыг хоёрдугаар, Сэтгүүлийн зөвлөлийн бүрдэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сэтгүүлийн бүтэц болон нийтлэлийн бодлогыг сэтгүүлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн баталж, сэтгүүлийг хагас жил тутам эрхлэн гаргах ажлыг зохион байгуулахыг Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч (Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дарга, бригадын генерал Б.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

3. Сэтгүүлийг Шинжлэх ухааны академийн Нийгмийн салбарын Бага чуулганаар хэлэлцүүлж, чансааг үе шаттай нэмэгдүүлж байхыг Сэтгүүлийн эрхлэгч (Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн захирал, хурандаа Ж.Амгалан)-д даалгасугай.

4. Сэтгүүл хэвлэн гаргах, зөвлөлийн гишүүний ажлын урамшууллыг зохих зардлаас тооцож олгохыг Санхүү, ар талын газар (хурандаа Я.Гантэмөр)-т зөвшөөрсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

00003988

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2022 оны 7 дугаар сарын 1 -ны өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт

"ГАМШИГ СУДЛАЛ, ИННОВАЦ" ОНОЛ, АРГАЗҮЙН МЭРГЭЖЛИЙН
СЭТГҮҮЛИЙГ ЭРХЛЭН ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргах "Гамшиг судлал, инновац" онол, аргазүйн мэргэжлийн сэтгүүлийг (цаашид "сэтгүүл" гэх) эрхлэн гаргахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Сэтгүүл нь гамшиг судлалын шинжлэх ухааны онол, арга зүйн мэргэжлийн цуврал сэтгүүл байх бөгөөд гамшигаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчин, практикт тулгамдсан асуудлыг шинжлэх ухаан, онол, арга зүй, дэвшилтэй технологи, удирдлага зохицуулалтын хүрээнд уламжлал, шинэчлэлийг хослуулан шийдвэрлэх талаар эрдэмтэн, судлаачдын шинжлэх ухаанч сэтгэлгээг дэмжих, тэдний үзэл бодол, дүгнэлт санал, судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох, гамшигаас хамгаалах талаарх төрийн бодлогыг сурталчлахад дэмжлэг үзүүлнэ.

1.3. Сэтгүүл нь кирилл болон монгол бичгээр "Гамшиг судлал, Инновац", англи хэлээр "Mongolian Journal of Disaster Research and Innovation" гэсэн нэртэй, гамшиг судлалын эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн мэргэжлийн хагас жил тутмын хэвлэл байх бөгөөд монгол хэл дээр хэвлэгдэн гарна. Онцгой тохиолдолд англи хэл дээр хэвлэн гаргаж болно.

1.4. Сэтгүүлийн үүсгэн байгуулагч нь Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн байх бөгөөд сэтгүүлийн нэрийг эзэмших эрх нь үүсгэн байгуулагчид хадгалагдана. Сэтгүүлийн үйл ажиллагаа ашгийн төлөө бус байна.

1.5. Сэтгүүл нь шуудангийн болон цахим хаягтай байх ба цахим хаяг нь сэтгүүлийн оноосон нэрийг агуулсан байна. Сэтгүүлийн албан ёсны хаяг нь Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн хаяг байна. (nidr-journal@nema.gov.mn, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Партизаны гудамж-5)

1.6. Сэтгүүл нь олон улсын стандарт цувралын дугаар (International Standard Serial Number) ISSN2790-1181, eISSN2790-119X бүртгэлээр баталгаажсан. Сэтгүүл нь цаасан болон цахим хэлбэрээр нийтлэгдэх бөгөөд цахим хэлбэр нь Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн цахим хуудаст байршина.

Хоёр. Нийтлэлийн бодлого, үндсэн агуулга

2.1. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь гамшигаас хамгаалах салбарт онол, практикийн хувьд тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны онол, арга зүйн үүднээс шийдвэрлэх арга замыг тодорхойлох, түгээн дэлгэрүүлэх, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түүний үр дүн, ололтыг хэрэглээнд нэвтрүүлж инновац болгох аливаа шинжлэх ухаанч, бүтээлч санал, санаачилгыг хөхиүүлэн дэмжих, иргэд, олон нийтийн гамшигаас хамгаалах боловсролыг дээшлүүлэхэд оршино.

2.2. Сэтгүүл нь дараах бүтэцтэй байж болох бөгөөд нийтлэх бүтээлийг дор дурдсан дэс дарааллыг харгалзан байршуулна.

- I. Гамшигаас хамгаалах бодлого, эрхзүй
- II. Гамшигаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээ
- III. Гамшигаас хамгаалах салбарын түүхэн хөгжил, шинэчлэл

IV. Эрдэмтэн, судлаачдын үзэл бодол

V. Дэвшилтэт технологи, инновац

VI. Олон улсын туршлага, сургамж

2.3. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээл тус бүрд хянан магадалгаа (англ. a *Peer Review*) хийх бөгөөд хянан магадалгааг хараат бусаар хийж, үр дүнг зохиогчид тодорхой мэдээлнэ.

2.4. Сэтгүүлийн хянан магадалгаа нь бүтээлийн зохиогч болон хянан магадлагч сэтгүүлийн зөвлөлийн гишүүний аль аль тал нь нэгнээ мэдэх боломжгүй (англ. *Double-blind peer-review*) байна.

2.5. Сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийг аюулгүй байдал, гамшиг судлалын чиглэлээр сургалт явуулж буй их, дээд сургуулийн магистр, докторын сургалтын хөтөлбөрт зохих итгэлцүүрийг ашиглан эрдэм шинжилгээний багц цаг тооцож болно.

2.6. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд уг бүтээлийн ашиглалт, эрхийн хамгаалалт нь хууль, тогтоомжид заасны дагуу хамгаалагдсан байна. Зохиогч бүтээлээ нийтлүүлэхээр ирүүлснээр бүтээлийг нийтлэх, нийтэд түгээхийг сэтгүүлд зөвшөөрсөн гэж ойлгоно.

Гурав. Сэтгүүлийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сэтгүүлийн удирдлагыг Сэтгүүлийн зөвлөл (цаашид "зөвлөл" гэх) хэрэгжүүлнэ. Сэтгүүлийн зөвлөл нь нийтлэлийн бодлогыг тодорхойлох санал, шүүмж өгөх, бүтээлийн чанарт хяналт тавих зэргээр чанар агуулгыг сайжруулахад дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

3.2. Сэтгүүлийн зөвлөл нь ерөнхий эрхлэгч, эрхлэгч, хариуцлагатай нарийн бичгийн дарга, техник редактор гэсэн байнгын, бүтээлд хяналт, үнэлгээ хийх үүрэг бүхий аюулгүй байдал, гамшиг судлал, бусад холбогдох салбарын эрдэмтдээс бүрдсэн редакцын зөвлөлийн байнгын бус гишүүдээс бүрдсэн 23 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна. Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр ажиллана.

3.3. Сэтгүүлийн редакцын зөвлөлийн бүрэлдэхүүнийг Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн даргын санал, сэтгүүлийн байнгын зөвлөлийн саналыг харгалзан Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар З жилийн хугацаатайгаар батална. Сэтгүүлийн редакцын зөвлөлийн бүрэлдэхүүний идэвх оролцоог харгалзан улируулан томилох эсхүл өөрчилж болно.

3.4. Сэтгүүлийн байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн

3.4.1. Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч нь Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дарга, эрхлэгч нь Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн захирал, Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга нь мөн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, техникийн редактор нь мөн хүрээлэнгийн Инновацын төвийн дарга тус тус байна.

3.5. Сэтгүүлийн редакцын зөвлөлийн бүрэлдэхүүн

3.5.1. Сэтгүүлийн редакцын зөвлөлийн бүрэлдэхүүн нь докторын зэрэгтэй, холбогдох салбар шинжлэх ухаанаар өндөр мэргэшсэн, олон улсад болон дотоодод нэр хүнд бүхий эрдэмтдээс бүрдэнэ. Сэтгүүлд ирүүлсэн өгүүллийн сэдэв, чиглэлийг харгалзан хариуцлагатай нарийн бичгийн даргын санал болгосноор сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүнийг сэтгүүлийн байнгын зөвлөл сонгож ажиллуулна.

3.6. Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч нь дараах бүрэн эрхтэй:

3.6.1. Сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг, томилох, өөрчлөх санал оруулах;

3.6.2. Сэтгүүлийн зөвлөлийн хуралдааныг зарлах, даргалах;

3.6.3. Энэ журмын 3.10.3-т заасан хянан магадалгааг үндэслэн тухайн дугаарт хэвлэх нийтлэлийн жагсаалтыг батлах болон журамд заасан бусад бүрэн эрх.

3.7. Сэтгүүлийн эрхлэгч нь дараах бүрэн эрхтэй:

3.7.1. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлсон саналаа сэтгүүлийн зөвлөлийн даргад танилцуулах;

3.7.2. Сэтгүүлд ирүүлсэн нийтлэлийг сэтгүүлийн зөвлөлийн гишүүдэд мэргэшсэн чиглэлийг нь харгалзан хянан магадалгааг хараат бусаар хийх боломжоор хангах;

3.7.3. Сэтгүүлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах, сэтгүүлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаанд хяналт тавих болон журамд заасан бусад бүрэн эрх.

3.8. Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.8.1. Сэтгүүлд ирүүлсэн нийтлэлийг хүлээн авах, бүтээлд тавигдах шаардлага хангуулах;

3.8.2. Сэтгүүлд ирүүлсэн нийтлэлийг сэтгүүлийн зөвлөлийн гишүүдэд мэргэшсэн чиглэлийг нь харгалзан хянан магадалгаа хийлгэхээр хуваарилах;

3.8.3. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүдэд хуваарилсан нийтлэлийг хүргүүлэх;

3.8.4. Бүтээлд тавигдах шаардлага хангагүй нийтлэлийг буцаах чиглэл өгөх;

3.8.5. Сэтгүүлийн үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангах;

3.8.6. Хянан магадлагдаж, бүтээлийн шаардлага, найруулга зүй, хэлзүйн хувьд шаардлага хангасан бүтээлийг хэвлүүлэх зөвшөөрөл олгох;

3.8.7. Сэтгүүлтэй холбогдох өдөр тутмын үйл ажиллагааг сэтгүүлийн эрхлэгчид тайлгаха;

3.9. Сэтгүүлийн техникийн редактор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1. Сэтгүүлийн зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн хянан магадалгааны дагуу зохиогчид хариу мэдээлэх;

3.9.2. Сэтгүүлийг хэвлэлд бэлтгэх, хэвлүүлэх Үүнд: эх бэлтгэл, дизайн, гарчиг, бүлэг, дэд бүлэг, зүйл зэргийн хуваарилалт, хавтас болон бүтээлийн өнгө үзэмж, зураг, дүрсний шаардлагыг сайтар хангах, ямар нэг техник алдаагүй байх гэх мэт;

3.9.3. Сэтгүүлийн цахим шуудан болон цахим сүлжээн дэх хуудсыг хөтлөх;

3.9.4. Сэтгүүлийг сурталчлах ажиллагааг хариуцах;

3.9.5. Сэтгүүлийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөх.

3.9.6. Сэтгүүлийн талаарх үнэн зөв мэдээллийг холбогдох этгээдэд өгөх болон журамд заасан бусад үүрэг.

3.10. Сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүн нь дараах бүрэн эрхтэй:

3.10.1. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого, чиглэлийг тодорхойлоход санал өгөх;

3.10.2. Сэтгүүлийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.10.3. Мэргэшсэн чиглэлийнхээ хүрээнд бүтээлд хянан магадалгаа хийж, санал, дүгнэлт гаргах, мэргэжлийн түвшинд зөвлөгөө өгөх;

3.10.4. Сэтгүүлийн үйл ажиллагааг дээшлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

3.10.5. Сэтгүүлд нийтлэлээ өгсөн тохиолдолд хураамжаас чөлөөлөгдөх;

3.10.6. Хянан магадалгаа хийсэн нийтлэлийн тоонд нийцүүлэн урамшуулал авах.

3.11. Сэтгүүлийн зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр хуралдаан байна. Зөвлөлийн хуралдааныг сэтгүүлийн зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

3.12. Хянан магадалгаа хийсэн редакцын зөвлөлийн гишүүний хянан магадалгааны дүгнэлтэд үндэслэн хариуцлагатай нарийн бичгийн дарга сэтгүүлд хэвлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Дөрөв. Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлд тавигдах шаардлага

4.1. Сэтгүүлд олон улсын болон үндэсний эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчим, хөгжлийн чиг хандлага, сэтгүүлийн нийтлэлийн бодлогод нийцсэн, хянан магадалгаа хийж зөвшөөрөгдсөн, шаардлага хангасан бүтээлийг нийтэлнэ.

4.2. Сэтгүүлд нийтлэгдэх эрдэм шинжилгээний бүтээл нь энэ журмын 2 дугаар зүйлд заасан сэтгүүлийн нийтлэлийн бодлого, агуулгад нийцсэн болон бичиглэлийн шаардлага хангасан байна.

4.3. Сэтгүүлд хэвлэгдэх эрдэм шинжилгээний бүтээл нь дараах төрөлтэй байна.

4.3.1 Эрдэм шинжилгээний өгүүлэл;

4.3.2 Эсээ;

4.3.3 Судалгааны үр дүн, тойм;

4.3.4 Эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмж;

4.3.5 Шинжлэх ухаан, технологи, инновацын шинэ мэдээлэл, орчуулгын бүтээл.

4.4 Энэ журмын 4.3 дахь хэсэгт зааснаас өөр төрлийг сэтгүүлд хэвлэх эсэхийг хариуцлагатай нарийн бичгийн даргын саналыг үндэслэн Сэтгүүлийн зөвлөл шийдвэрлэнэ.

4.5. Сэтгүүлийн нэг дугаарын нэг буланд зохиогч нэг нийтлэл өгнө.

4.6. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн аливаа бүтээл нь дараах нийтлэг шаардлагыг заавал хангасан байна:

4.6.1. Бүтээлийн нэр, зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй албан тушаал нь монгол, англи хэл дээр байх;

4.6.2. Бүтээлээ ирүүлэхдээ зохиогчийн зураг (300-аас доошгүй нягтаршилтай, dpi, .jpg, .psd өргөтгөлтэй), цахим шуудан, холбоо барих утасны дугаарыг хавсаргасан байх;

4.6.3. Бүтээлийг MS Word программаар, үндсэн бичвэрийг Times New Roman, 11 pt, мөр хоорондын зайд 1 (single); эшлэл, зүүлтийг Times New Roman, 10 pt, мөр хоорондын зайд 1 (single) хэмжээтэй байхаар бичих бөгөөд .docx өргөтгөлөөр ирүүлэх;

4.6.4. Бүтээл нь гадаадын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өмнө нь хэвлэн нийтлэгдээгүй байх;

4.6.5. Агуулгын хувьд зохиогчийн эрх зөрчөөгүй байх;

4.6.6. Эшлэл, зүүлтийг стандартын дагуу тэмдэглэсэн, зохиогчийн эрхийн зөрчилгүй, зүй бус хэллэг ашиглаагүй байх;

4.6.7. Эшлэлийг [1] гэж тэмдэглэнэ. Ишлэл авсан номыг зөв дугаарлаж, тодорхой бичнэ.

4.6.8. Өгүүлэлд хэрэглэсэн хэмжигдэхүүнийг Олон улсын СИ системээр тэмдэглэнэ.

4.8. Эрдэм шинжилгээний өгүүлэл

4.8.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах бүтэцтэй байна.

Өгүүллийн нэр (монгол, англи хэлээр)

Зохиогчийн овог, нэр; эрдмийн зэрэг, цол, байгууллага/албан тушаал (монгол, англи хэлээр)

Хураангуй (монгол, англи хэлээр)

Түлхүүр үг (монгол, англи хэлээр)

Оршил (судалгааны асуудал, үндэслэл)

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааны үр дүн

Хэлэлцүүлэг

Дүгнэлт, санал

Номзүй

4.8.2. Өгүүлэл нь нэр, түлхүүр үгс, хураангуй, эх сурвалжийн жагсаалт, хавсралтаас гадна 2500-аас доошгүй үтгэй байна.

4.8.3. Түлхүүр үгс нь 5 хүртэлх тооны нэр үгээс бүрдэх ба бүтээлийн гарчигт ороогүй үгээс бүрдсэн байна.

4.8.4. Хураангуй нь өгүүллийн агуулгыг ойлгомжтой байдлаар хураангуйлсан тухайн өгүүлэлд орсон судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол, аргазүй, үр дүнг зэргийг товчлон багтаасан байна. Хураангуйд өгүүллийн аль нэг хэсгээс шууд хуулбарлаагүй байвал зохино.

4.8.5. Оршил хэсэгт судалгааны хэрэгцээ шаардлага, дэвшүүлэн тавьж судалсан асуудал, тухайн асуудлын судлагдсан байдлыг товчон оруулна.

4.8.6. Судалгааны арга зүй, аргачлал нь судалгаанд хэрэглэсэн арга зүй, онолыг багтаасан байна. Мөн материал боловсруулалтын аргачлалуудыг заавал бичнэ.

4.8.7. Судалгааны үр дүн нь тухайн судалгааны арга зүйн дагуу ямар үр дүн гарсан эдгээр нь бусад судлаачдынхаас ямар ялгаатай, ямар сүл болон давуу талтай болохыг зөвхөн тухайн сэдвийн хүрээнд харьцуулан дэлгэрэнгүй өгүүлсэн байна.

4.8.8. Хэлэлцүүлэг хэсэг нь зөвхөн тухайн судалгааны өнөөгийн болон цаашид хийгдэх ажилд чиглэгдсэн байх ба энэ ажилд гарсан урьдчилсан дүгнэлтүүдийг хэрхэн сайжруулах, тухайн сэдвээр бусад судлаачдын явуулсан судалгааны дүнтэй харьцуулалт хийж дэлгэрэнгүй тайлбарлан бичнэ.

4.8.9. Дүгнэлт хэсэгт үндсэн хэсэгт дурдаагүй шинэ санаа оруулахгүй бөгөөд судалгааны ажлын ерөнхий үр дүн, тэдгээрийн онол арга зүй, практик үйл ажиллагаанд ашиглах боломж зэргийг тусгана.

4.8.10. Талархал хэсэг байж болно. Энд тухайн судалгааг явуулж тодорхой үр дүн гаргахад туслалцаа үзүүлсэн хувь хүн, байгууллага, баг, хамт олон, эрдэмтэн багш нарт талархал илэрхийлж болохын зэрэгцээ судалгаа явуулсан сэдэв, төслийн нэрийг бичнэ.

4.9. Эсээ

4.9.1 Эсээ нь гамшиг судлалын шинжлэх ухааны хүрээн дэх аливаа асуудлаар өөрийн үзэл бодол, чөлөөт сэтгэлгээг шинжлэх ухаанчаар илэрхийлэн бичсэн байна.

4.9.2 Эсээ нь 3000-аас дээшгүй үтгэй байна. Бичиглэлийн шаардлагын хувьд эрдэм шинжилгээний өгүүлэлтэй тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална.

4.10. Судалгааны үр дүн, тойм

4.10.1 Судалгааны үр дүн, тойм гэдэгт гамшиг судлалын шинжлэх ухааны хүрээн дэх аливаа төсөл, бодлогын судалгааны тайлан, үр дүн, танилцуулга, тойм хураангуйг ойлгоно.

4.10.2 Сэтгүүлд нийтлэгдэх судалгааны үр дүн, тойм нь эрдэм шинжилгээний өгүүлэлтэй нэгэн адил бичиглэлийн шаардлагыг хангасан байна. Судалгааны үр дүн, тойм нь хураангуй, түлхүүр үг, ном зүйн жагсаалтыг оролцуулалгүйгээр 4000-аас дээшгүй үтгэй байна.

4.11. Эрдэм шинжилгээний бүтээлийн шүүмж

4.11.1 Бүтээлийн шүүмжийг тухайн зохиогчоос өөр судлаач бичсэн байна.

4.11.2 Шүүмж нь тухайн бүтээлийн шинжлэх ухааны үнэ цэнэ, шинжлэх ухаанд оруулах хувь нэмэр, практик болон онолын ач холбогдолд үнэлэлт өгсөн байх бөгөөд харин зохиогчид нь субъектив байдлаар дүгнэлт хийхээс ангид байвал зохино.

4.11.3 Шүүмжийг гамшиг судлалын шинжлэх ухааны хүрээн дэх эрдэм шинжилгээний бүтээлд (нэг сэдэвт зохиол, өгүүлэл, илтгэл гэх мэт) мөн энэ салбарын бодлого, хөтөлбөр болон эрхзүйн баримт бичигт бичиж болно. Сурах бичиг, магистр, докторын зэрэг горилох бүтээлд өгөх шүүмж хамаarahгүй.

4.11.4. Шүүмж нь 3000-аас дээшгүй үтгэй байна.

4.12. Шинжлэх ухаан, технологи, инновацын шинэ мэдээлэл, орчуулгын бүтээл.

4.12.1. Гамшиг судлалын салбарт гарсан шинэ, технологи, инновац, болсон цаг үе, үйл явдлын тухай мэдээлэл, гамшиг судлалын шинжлэх ухааны салбарт шинээр төрөн гарсан бүтээл, эрдэмтний тухай мэдээллийг нийтэлнэ.

Тав. Бүтээл хүлээн авах, хэвлэх эсэх дүгнэлт гаргах

5.1. Бүтээл хүлээн авах

5.1.1. Шаардлага хангасан бүтээлийг хариуцлагатай нарийн бичгийн дарга З ба 8 дугаар сарын 15-аас 4 ба 9 дүгээр сарын 15-ны хооронд хүлээн авна.

5.1.2. Зохиогч нийтлүүлэх бүтээлийн эхийг сэтгүүлийн цахим хаягаар ирүүлэх бөгөөд бүтээлийг хүлээн авсан бүртгэлд хүлээлгэн өгсөн он, сар, өдөр, цаг, бүтээлийн нэр, хуудасны тоо зэргийг тэмдэглэн, ирүүлсэн хаягаар хариу цахим шуудан хүргүүлнэ. Сэтгүүлтэй холбоотой цахимаар харьцах бүх асуудлыг зөвхөн тухайн сэтгүүлийн цахим хаягаар дамжуулна.

5.1.3. Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээл нь энэ журмын 4.6-д заасан шаардлагыг эс хангасан бол сэтгүүлийн редакц шаардлага хангуулахаар зохиогчид буцаах ба буцаасан тохиолдолд заасан хугацаанд дахин шаардлага хангахгүй бол хүлээн авахаас татгалзана. Татгалзах шийдвэрийг редакцын зөвлөлийн гишүүний саналыг үндэслэн хариуцлагатай нарийн бичгийн дарга гаргана.

5.2. Бүтээлийг хэвлэх эсэх дүгнэлт гаргах

5.2.1. Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга редакцын зөвлөлийн гишүүний мэргэшсэн чиглэлийг нь харгалзан хянан магадалгаа хийлгэхээр хуваарилж, хүргүүлнэ.

5.2.2. Редакцын зөвлөлийн гишүүн зохиогчийн сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээлийг хянан магадалгаа хийж үнэлгээ өгөх хуудаст заасан шалгуураар үнэлж, уг бүтээлийг цаашид сэтгүүлд нийтлэх эсэх талаарх дүгнэлт, эсхүл цаашид бүтээлийг сайжруулах талаарх саналын хамт хариуцлагатай нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

5.2.3. Редакцын зөвлөлийн гишүүн нь сэтгүүл хэвлэгдэн гарахаас 1 сарын өмнө бүтээлийг хэвлэх эсэх дүгнэлтийг гаргасан байвал зохино.

5.2.4. Сэтгүүлийн зөвлөлийн сэтгүүл хэвлэх эсэх шийдвэр гарсны дараа техникийн редактор мэдэгдлийг зохиогчид хүргүүлнэ.

Зургаа. Сэтгүүлийг хэвлэх ба түгээх

6.1. Сэтгүүлийн хэвлэлт

6.1.1. Сэтгүүлийг В5 хэмжээтэйгээр монгол хэлээр хэвлэнэ. Шаардлагатай тохиолдолд англи хэл дээр хэвлүүлж болно.

6.1.2 Сэтгүүлийг хагас жилд нэг удаа эрхлэн гаргана. Шаардлагатай тохиолдолд ерөнхий эрхлэгчийн зөвшөөрлөөр сэтгүүлийн тусгай дугаарыг эрхлэн гаргаж болно.

6.1.3 Сэтгүүлийн талаарх мэдээлэл, нийтлэгдсэн бүтээлийн хураангуйг Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн цахим хуудаст байршуулах бөгөөд бүрэн эхээр байршуулж болно.

6.2. Сэтгүүлийг түгээх, олон нийтэд таниулах

6.2.1. Сэтгүүлийг Онцгой байдлын байгууллагын нийт алба хаагч, эрдэмтэн, судлаач, суралцагч нарт нэн тэргүүнд хүргэнэ. Холбогдох төрийн байгууллага, их, дээд сургууль, судалгааны хүрээлэн, төвд түгээнэ.

6.2.2. Бүтээлээ нийтлүүлсэн зохиогчид тухайн дугаарын сэтгүүлийн нэг хувийг үнэ, төлбөргүй олгоно.

6.2.3. Сэтгүүлийн нэр хүндийг өсгөх, мэргэжлийн хүрээнд нийтэд хүртээмжтэй болгох, зохиогч болон нийтлэгдсэн бүтээлийг сурталчлах, мэргэжлийн хүрээнд таниулах ажлыг сэтгүүлийн зөвлөл зохион байгуулна.

6.2.4. Сэтгүүлийн түгээлтийг хүрээлэнгийн Захиргаа хариуцах бөгөөд сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга түгээлтийн жагсаалтыг хагас жил тутамд шинэчлэн гаргаж өгнө. Түгээлтийн мэдээлэл, баримтын хуулбарыг сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн даргад санхүү, нярав хүлээлгэн өгсөн байна.

Долоо. Сэтгүүлийн санхүүжилт

7.1 Сэтгүүлийн санхүүжилт нь Онцгой байдлын ерөнхий газрын төсөвт үндэслэнэ.

7.2 Сэтгүүл нь улсын төсөв, үйл ажиллагааны орлого, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө, хууль тогтоомжоор хориглосноос бусад эх үүсвэрээс санхүүжиж, ижил чиглэлийн бусад байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллаж болно.

7.3. Сэтгүүлийн нийтлэлд хянан магадалгаа хийлгэх хураамж 50.000 /тавин мянга/ төгрөг байна. Хураамжийг сэтгүүлийн хянан магадалгааны урамшуулалд зарцуулна. Хянан магадалгааны үр дүн ямар байхаас үл хамааран хураамжийг буцаан олгохгүй.

7.4. Сэтгүүлд нийтлэх нэгж бүтээлийн хянан магадалгааны урамшуулал 50.000 /тавин мянга/ төгрөг байна.

7.5. Сэтгүүлд гамшиг судлалын шинжлэх ухааны салбарын тодорхой салбараар өндөр мэргэшсэн, нэр хүнд бүхий эрдэмтэн, судлаач /доктороос доошгүй эрдмийн зэрэгтэй/-аар захиалгат нийтлэл бичүүлэн хэвлэн нийтэлж болно. Захиалгат нийтлэлийн нэгж бүтээлийн хөлс 100.000 /зуун мянга/ хүртэлх төгрөг байна.

7.6. Сэтгүүлийн байнгын зөвлөлийн гүйцэтгэсэн үүрэг, оролцоог харгалзан сэтгүүлийн дугаарыг эрхлэн гаргасан тухай бүр урамшуулал олгоно.

Найм. Бусад

8.1. Сэтгүүлийг хэвлэх, үдэх ажиллагааны явцад хуудас солигдох, үсэг бүдэг гарах, өнгө үзэмж муу, техник алдаа гарах, үг, үсэг, найруулгын илэрхий алдаа гаргасан хугацаа хожимдуулсан зэргээс үүдэн хохирол гарсан тохиолдолд буруутай этгээдэд хариуцлага тооцно.

8.2. Уг журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, сэтгүүлийн редакцын зөвлөл гаргаж болно.

ГАМШИГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Онцгой байдлын өрөнхий газрын даргын
2022 оны 9 дугаар сарын 29-ны өдрийн
А/251. тушаалтын хоёрдугаар хавсралт

“ГАМШИГ СУДЛАЛ, ИННОВАЦ” сэтгүүлд хэвлүүлэхээр ирүүлсэн өгүүлэлд хянан
магадалгаа хийж үнэлгээ өгөх хувудас

нэр/код :

/өгүүллийн нэр болон уг журмын 4.3-т заасан бичвэрийн төрлийн аль тохирохыг бичнэ./
(үнэлгээний оноо 2-сайн, 1-дунд, 0-хангалтгүй)

№	Өгүүлэлд үнэлгээ өгөх үзүүлэлтүүд	Үнэлгээ	Тайлбар
	1. Өгүүллийн нэр		
1.1	Тодорхой бөгөөд оновчтой байдал		
	2. Оршил		
2.1	Судалгааны ажлын талаарх үндэслэл, үндсэн мэдээлэл, зорилго оновчтой дэвшигдсэн байдал		
2.2	Судалгааны ажлын таамаглал, судлах зүйлийг тодорхойлж дэвшүүлсэн байдал		
	3. Судалгааны материал, арга зүй, явц		
3.1	Судалгааны арга зүй, төлөвлөлтийг сонгосон, түүнийг илэрхийлж томьёолсон байдал		
3.2	Судалгааны аргыг оновчтой тодорхойлсон байдал		
	4. Судалгааны үр дүн		
4.1	Судалгааны үр дүнг бичгээр илэрхийлж тайлбарласан байдал		
4.2	Шаардлагатай хүснэгт, зураг, диаграммыг оруулсан, ашигласан байдал, форматын дагуу гүйцэтгэсэн байдал		
4.3	Судалгааны үр дүнг бусад судлаачдын гаргасан үр дүнтэй харьцуулсан байдал, ишлэл зүүлт хэрэглэсэн байдал		
4.4	Судалгааны үр дүн боловсруулалтын оновчтой арга хэрэглэж, үр дунд оновчтой дүн шинжилгээ хийсэн байдал		
4.5	Баримт, тооцоо, тайлбар дүгнэлт зөв хийгдсэн байдал		
	5. Хэлэлцүүлэг		
5.1	Гарсан үр дүнгийн талаар зохих хэлцэмж дэвшүүлсэн эсэх		
5.2	Гарсан үр дүнгээс хийх дүгнэлт, тайлбар оновчтой эсэх		
5.3	Баримт, тооцоо, тайлбар дүгнэлт зөв хийгдсэн сэх		
5.4	Тайлбар, дүгнэлтүүдийг өмнө хэвлэгдсэн эх үүсвэрүүдтэй харьцуулсан байдал		
	6. Ашигласан хэвлэл		
6.1	Ашигласан материалыг оновчтой бөгөөд хангалттай авсан эсэх		
6.2	Эшлэлийг зөв хийсэн эсэх		
6.3	Ном зүйн жагсаалтыг зөв формат-д оруулсан байдал		
	7. Хураангуй		
7.1	Өгүүллийн хураангуйн агуулга, хэмжээ, өгүүлсэн байдал оновчтой эсэх		
7.2	Англи хэл дээр хөрвүүлсэн байдалд өгөх үнэлгээ		
	Ерөнхий дүгнэлт		
7.3	Өгүүллийн өрөнхий бичлэг, логик бүтцийн талаарх үнэлгээ НЭГДСЭН ДҮГНЭЛТ		
7.4	Өгүүллийг уг сэтгүүлд хэвлэхийг зөвшөөрч байгаа эсэх (нийт оноо/40=....%)		
	i. Хэвлэх /36-40 оноо/ ii. Нэхцэлтэйгээр хэвлэх, бага засвартай /31-35 оноо/ iii. Нэхцэлтэйгээр хэвлэх, их засвартай /25-30 оноо/ iv. Эс хэвлэх /24-өөс доош оноо/		

Жич: Тайлбар хэсэгт шинжээч өгсөн онооныхоо тайлбар, үндэслэлийг тодорхой бичих ба хэрэв
засвар хийх шаардлагатай гэж үзвэл тэр талаар товч тодорхой бичих.

Хянан магадалгаа хийсэн редакторын гишүүний нэр: /

Гарын үсэг

/огноо/